

# 외국인 유학생 건강보험 적용 안내

Guide for International Students Subscribing  
to National Health Insurance



## Болзол Хангаж Буй Этгээдүүд

- Олон улсын оюутнууд, гадаадын иргэд болон гадаадад оршин суугч Солонгос иргэд

## Бүртгүүлэх Хугацаа

Визний Ангилал	Бүртгүүлэх Хугацаа
Гадаадад суралцах (D-2), Бага/Дунд/ Ахлах сургуулийн сургачид (D-4-3)	Анх хилээр нэвтрэн орсоны дараа ➔ Гадаад иргэний бүртгэл хийлгэсэн огноо
D-4-3 ангиллаас бусад ерөнхий сургалт дадлага (D-4)	Хилээр дахин нэвтрэн орсоны дараа ➔ Хилээр дахин нэвтрэн орсон огноо
Гадаадад суралцагч Солонгос оюутнууд болон олон улсын оюутнууд	Хилээр нэвтрэн орсоноос зургаан сарын дараа
	Сургуульд элсэн орсон өдөр (элсэн суралцах зэвшөөрлийн хуулбарыг өгсөн тохиолдолд)

\* Хэрэв та гадаад улсын хууль тогтоомж, гадаадын даатгал эсвэл ажил олгогчтой байгуулсан гэрээний дагуу эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хөнгөлөлттэй (Үндэсний Эрүүл Мэндийн Даатгалын Хуулийн 41-р Зүйл) тэнцүү хэмжээний эрүүл мэндийн тэтгэмж хүлээн авч буй бол даатгалд хамрагдахаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно.

## Шимтгэл

- (Шимтгэлийг Төлөх)
  - (Эцсийн Хугацаа) Дараагийн сарын шимтгэлийг одоогийн сарын 25 гэхэд төлсөн байх ёстой (урьдчилсан төлөлт).
  - (Жишээ) 2021 оны 4-р сарын шимтгэл → 2021 оны 3-р сарын 25 гэхэд төлөх (сар бүрийн 10-ны орчим нэхэмжлэл очно)

- (Төлбөр Хийх Хэлбэр) Шууд Татах (таны банкны данс эсвэл кредит картнаас), вебсайт, ҮЭМДҮ-ний Төв, банкууд
- (Цахим нэхэмжлэл, Шууд Татах Төлөлтөнд бүртгүүлэх эсвэл Буцаан Олголт Авах Данс бүртгүүлэх бол): Бүртгүүлэхийн тулд вебсайт эсвэл ҮЭМДҮ-ний төвд зочлох эсвэл залгана уу.
  - Та цаасан нэхэмжлэл хүлээн авахын оронд цахим (э-мэйл эсвэл гар утас) нэхэмжлэл хүлээн авахаар өргөдөл гаргаж болно.
  - Төлбөр төлөлтийг хялбарчлах үүднээс төлбөр шууд татах сонголтонд өргөдөл гаргана уу. Буцаан олголтыг Android iPhone (iOS) түргэн шуурхай хүлээн авахын тулд банкны дансаа бүртгүүлнэ үү.



Э-нэхэмжлэл авах боломжтой



## Шимтгэл Төлөөгүйн Улмаас Үүсэх Сөрөг Талууд

- (Эрүүл Мэндийн Даатгалаар Эдлэх Хөнгөлөлт Хязгаарлагдана) Төлбөр төлөх эцсийн хугацаа хэтэрсэний дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тухайн шимтгэлийг бүрэн төлж дуусах хүртэл Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний байгууллага дээр Эрүүл Мэндийн Даатгалын хөнгөлөлтийг эдлэх боломжгүй.



## Сөүл хот дахь Гадаад иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авах төв үйл ажиллагааны танилцуулга

Эрүүл мэндийн даатгалын үндсэн төв нь гадаад иргэдийн зруул мэндийн даатгалтай холбоотой үйл ажиллагааг илүү шуурхай мэргжиллийн түвшинд гүйцэтгэжийн тулд Гадаад иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авах төвийг ажиллуулж байгаа болно.

### Хамрагдах эрх

**Сөүл** хотод оршин суудаг гадаад иргэд болон хилийн чанадад оршин сууж буй солонгос иргэд

### Гүйцэтгэх үүрэг

Орон нутгын татварт бүртгэлтэй болон ажлын байрны хамааралтай буюу ажил хийдэг бол **татвартай холбоотойгоор биечлэн** ирж өргөдөл хүсэлт гаргасан бичиг баримт зохицуулах

### Байршил

97, Saemal-ro, Guro-gu, Seoul, Синдорим TECHNO MART Офисс товлөрсон төв 3-н давхар(Худалдааны төв ×)

### Хийж ирж хажуул

#### Хурааны голт тэрэг

1.2 дугаар шугам Синдорим өртөө 3-р гарц

- Синдорим TECHNO MART подвалын 1 давхартай холбогдсон  
(Офиссын товлорсон төв байрны чиглэлд, Худалдааны төв ×)

#### Автобус


Синдорим өртөөн дээр буух

- Автобус: 5619,6411,6511,6611, ЕндонПу(01,08,09,12,13)

#### Авто машин

Авто зогсоолын бус- B6F/Зөвхөн B3F - B4F хэсэг нь 10 цаг 30 минутаас хойш изэлтгэй бодло

- Авто зогсоолын телбор : 1 цаг үнзгүй ба(давхарын кассанд шалгуулан шалгуулан 2 цагаар нэмж болно)



☏ 033-811-2000

⇒ Англи, Хятад, Вьетнам, Узбек улсын иргэдэл зөвлөгөө огох

☏ 1577-1000

⇒ Гадаад хэлээр 7 номер зөвлөгөө огне

\* Зөвлөгөө авч болох цаг: Ажлын одруудаар 09:00-18:00 цагийн хооронд